



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 05 сарын 31 өдөр

Дугаар A/45

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
олгох, хүчингүй болгох тухай

Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Бодь Монгол ХХК-ийн “Бэст центр” зочид буудлын 17/099, ММС Поларис ХХК-ийн “Ибис стайлс Улаанбаатар” зочид буудлын 17/109, Кондитер Улаанбаатар ХХК-ийн “Шинэ Алтай” зочид буудлын 17/100, Хаан палас ХХК-ийн “Кемпински” зочид буудлын 17/112, Золостар ХХК-ийн

1150500151

“Золо” зочид буудлын 17/023, Сэрх-Уул ХХК-ийн “Алтан цайз 1” дэн буудлын 17/113, Хонгор экспедишн ХХК-ийн “Хонгор” дэн буудлын 17/114 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 31 өдрийн А/45 дугаар
тушаалын нэгдүгээр хавсралт

9020025 СБТ-8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.05.31

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Бодь Монгол ХХК	2679639	Бэст центр	ЧД-ийн 5-р хороо Их тойруу 15
2	ММС Поларис ХХК	5893003	Ибис стайлс Улаанбаатар	ХУД-ийн 2-р хороо Чингисийн өргөн чөлөө 81
3	Кондитер Улаанбаатар ХХК	2626942	Шинэ алтай	СХД-ийн 18-р хороо ЭТӨЧ 18
4	Хаан палас ХХК	2873877	Кемпински	БЗД-ийн 4-р хороо Их тойруу 178
5	Золостар ХХК	5165585	Золо	СБД-ийн 3-р хороо Нарны зам 71

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 31 өдрийн А/45 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

52340.25 СБТ 8936 1116263502

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.05.31

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Сэрх-Уул ХХК	2657112	Алтан цайз 1	БЗД-ийн 22-р хороо Өлгийн 10-154
2	Хонгор экспедишн ХХК	2582627	Хонгор	ЧД-ийн 3-р хороо тавин мянгатын 15-5

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2018 оны 05
сарын 31-өдрийн А/45 дугаар
тушаалын гуравдугаар хавсралт

5284325 СБТ 0936 1118263502

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2018.05.31

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	ЭСДЛ ХХК	5131111	Цэцээ гүн	БЗД-ийн 11-р хороо Төрхурахын ам

-ooOoo-